



ДУНДГОВЬ АЙМГИЙН ЦАГААНДЭЛГЭР СУМАНД "САГСНЫ ТАЛБАЙ ШИНЭЭР
БАРИХ" АЖЛЫН ГЭРЭЭ
ДУГААР № ДУГАЦДСЗДТГ/202304014

2023.05.31

Хараат

Нэг талаас (цаашид "Захиалагч" гэх) Засаг дарга А.Эрдэнэсайхан, нөгөө талаас "Тэргүүлэн" ХХК-ны захирал Г.Банзрагч (цаашид "Гүйцэтгэгч" гэх) нар дараах зүйлсийг харилцан тохиролцож 2023 оны 05 дугаар сарын 31 -ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид "гэрээ" гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа бүтээгдэхүүн нийлүүлэх, ажил гүйцэтгэхтэй холбогдон захиалагч, гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь Дундговь аймгийн Цагаандэлгэр сумын "Сагсны талбай шинээр барих" ажлыг ДУГАЦДСЗДТГ/202304014 дугаартай (цаашид "гэрээний үүрэг" гэх) 20000.00 (Хорин сая) төгрөгөөр гүйцэтгэхээр ирүүлсэн гүйцэтгэгчийн саналыг үүгээр хулээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь "Сагсны талбай шинээр барих" ажлын 20000.00 (Хорин сая) төгрөгийг орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжүүлнэ.
4. Гүйцэтгэгч нь тус сумын "Сагсны талбай шинээр барих" ажлыг зураг төсвийн дагуу чанартай гүйцэтгэнэ. Ажлыг 2023 оны 06 дугаар сарын 05 - ны өдөр эхлүүлж 2023 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн дотор гүйцэтгэнэ.
5. Санхүүжилтийг бараа материалаа татаж авч ирсний дараа 70%, ажлын гүйцэтгэл дууссаны дараа 30% олгоно.
6. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний хэсэг болно (цаашид "гэрээний баримт бичиг" гэх). Үүнд:

- 6.1 Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
- 6.2 Бусад шаардлагатай баримт бичиг;
- 6.3 Гүйцэтгэгчийн ирүүлсэн санал;
- 6.4 Гэрээний тусгай нөхцөл;
- 6.5 Гэрээний ерөнхий нөхцөл;
- 6.6 Ажлын зураг, техникийн тодорхойлолт
- 6.7 Гүйцэтгэгчийн ирүүлсэн үнэ бүхий үйл ажиллагааны хуваарь
- 6.8 Санхүүжилтийн хуваарь

Гэрээ нь энд дурдсан ажлыг гүйцэтгэх талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвэл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

7. Захиалагч, гүйцэтгэгч нь гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан эрх, үүрэг, хариуцлагыг хүлээнэ.
8. Гүйцэтгэгч нь гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан ажлыг гүйцэтгэж, зөрчил, гологдол арилгах үүрэг хүлээнэ.
9. Захиалагч нь гэрээний дагуу гүйцэтгэгчийн хийх ажил болон зөрчил, гологдол арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг хүлээнэ.
10. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр болон утсан холбоогоор харилцана.
11. Ажлыг батлагдсан зургийн дагуу гүйцэтгэх ба гэрээт хугацаандаа ашиглалтад өгөөгүй бол хэтэрсэн хоног тутамд гүйцэтгээгүй үнийн дүнгийн 3 хувиар алданги ногдуулна. Гэхдээ алданги хүлээнээр үүргийн гүйцэтгэлээс чөлөөлөгдөхгүй.

графикт зохицуулалт хийсний үндсэн дээр ажил дуусгах хугацаанд өөрчлөлт оруулж болно.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

ЦАГААНДЭЛГЭР СҮМЫН

ЗДТГ-ЫН ДАРГА

Ш.МОНХ-ОРГИЛ

ТУ21564 9033599 0820030006

ХАЯГ: Дундговь аймгийн Цагаандэлгэр

сум Хараат 1-р баг

Утас: 95971666

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

"ТЭРГҮҮЛЭН" ХХК-ИЙГ

ТӨЛӨӨЛЖК

ТЭРГҮҮЛЭН

ХХК

01790600

8219281781 1245497

ХАЯГ: Улаанбаатар хот

Харилцах банк: Хаан банк

Регистрийн дугаар: 3245497

Утас: 88081490